

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 91.040.10

Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага	MNS 6055 : 2009
Space and setting standard for disabled person in civil structure. General Requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн.51 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2010 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь иргэний (орон сууц, олон нийт) зориулалттай барилгын орчин, дотоод орон зайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийн зарим шаардлагыг тогтооход хамаарна.

2 Норматив ишлэл

- БНБД 31-01-01, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм,
- БНБД 31-03-03, Олон нийт, иргэний барилга,
- БД 31 -101-04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль
- MNS ISO 4190-2, 3, 5: 2003 "Зорчигчийн лифт ба үйлчилгээний лифт"
- MNS 5611: 2006, Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага,
- Архитектурная среда обитания инвалидов и престарелых. М:Стройиздат, 1989.
- Americans with Disabilities Act (Access Guide: Survey Checklist),
- European Manual for an Accessible Built Environment. CCPT, 1990,
- Barrier-Free Design. The Law. U.I.NY. 1989,
- ВСН 62-91, Проектирование среды жизнедеятельности с учетом потребностей инвалидов и маломобильных групп населения/Госстрой России. М.: ГП ЦПП, 1994,
- РДС 35-201-98, Порядок реализации требований доступности для инвалидов к объектам социальной инфраструктуры /Совет по делам инвалидов при Президенте Российской Федерации, Госстрой России. Минтруд России. М.: ГУН ЦПП. 1998.

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэх нэр, томьёог дараах утгаар ойлгоно.

3.1

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд энэ бэрхшээл нь орчны бусад хязгаарлалттай нэгдэн нийлж бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүмүүс

3.2

антропометр хэмжээ

хүний бие, түүний хэсгүүдийн өөрчлөлтийн системийг заасан гол хэмжээ

3.3

хаалганы орон зай

хаалганы хавтас 90° ба бүрэн онгойх үеийн хаалганы үүрийн өргөний хэмжээ

3.4

хөгжлийн бэрхшээлтэй хүн

эрүүл мэндийн хувьд төрөлхийн согогтой, биеийн үйл ажиллагаа, тэсвэр хатуужил муудаж доройтсон буюу өвчилсөн эсвэл бэртэж гэмтсэн, хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсан, амьдралын хүнд бэрхшээлд орсон хүн.

3.5

хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүс

ихэвчлэн 60 ба түүнээс дээш өндөр настай хүмүүс, 16-аас 60 насны хөдөлмөрийн чадвартай тахир дутуу, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхэд, түр зуурын хөдөлмөрийн чадваргүй, хүүхдийн тэргэнцэр хэрэглэдэг 8-10 насны хүүхэд багтана.

3.6

налуу зам

босоо чиглэлд барилгын гадна дотно хэсгийг холбосон налуу хавтгай

3.7

настай хүмүүс

өндөр настай хүмүүсийн бүлэг

3.8

тактильный

хараагүй хүнд овгор, товгор байдлаар мэдрэгдэх тэмдэглэгээ

3.9

бүсчлэл ба орон зай

хэмжигдэхүүний тоон утга (урт, өргөн өндөр)- Орон зай болон байгуулалт дээр ямар нэг юмны хоорондох хязгаарлалтыг заасан хэмжээ. (Жишээлбэл: хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх орон зайн өргөн, урт, тэргэнцрийн эргэх радиус, хүрч болох өндрийн хэмжээ г.м.)

3.10

үйл ажиллагаа-зориулалтын бүс

ямар нэг үйл ажиллагаатай холбогдсон орчны хязгаарлалтын шинж чанарыг тодорхой харуулсан орон зай. Жишээ нь: автомат-харилцуур утасны дэргэдэх орон зай, ширээ болон лангууны ойролцоох бүсчлэлийн орон зай г.м.

3.11

брайлын үсэг

хараагүй хүний тэмтэрч мэдрэхэд зориулагдсан товгор тэмдэглэгээ, бичиг

3.12

эргономик

хүний хөдөлгөөний орон зайнаас хамааруулсан гол хэмжээ

3.13

орон сууц

хүн байнга буюу түр оршин суух зориулалттай нэг ба олон айлын сууцны байшин

3.14

өрөө тасалгаа

үүрэг зориулалт нь тодорхой, барилгын хийц бүтээцээр хязгаарлагдсан барилга доторх орон зай

3.15

явган зам

явганаар, хүүхдийн тэрэг түрж, чарга чирч яваа хүн, 350 мм-ээс бага голч бүхий унадаг дугуйтай хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ролик, скейт борд, скоотертэй хүн

3.16

хөндлөн налуу

явган хүний замын хөндлөн хэвгий

3.17

замын хашлага

явган хүний зам, ногоон байгууламжийг автомашины замаас тусгаарласан явган хүний зорчих чөлөөний хэсэг

3.18

Элемент

ямарваа зүйлийг бүрдүүлэгч, язгуур хэсэг

3.19

ревербераци – дуу үүсгэгчийг зогсоосноос хойш дуу тархах хугацаа

3.20

Модель

биет загвар

4 Ерөнхий шаардлага

4.1 Энэхүү стандарт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогийг тусгайлан харгалзаж барилгын дотоод орон зай, орчинд нэвтрэн орох, зорчих, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад мөрдөнө.

4.2 Стандартын үндсэн хэсэг нь тулгуур эрхтэний гэмтэлтэй болон хараа, сонсголын согогтой хүмүүст зориулсан болно.

4.3 Стандартын шаардлагад сэтгэцийн хомсдолын хөнгөн хэлбэртэй, дотоод тархины гэмтэл, дотоод эрхтэний өвчний улмаас тахир дутуу болсон, мөн хэт өндөр настай, сул дорой биетэй хүмүүсийн хэрэгцээг тооцсон.

4.4 Сэтгэцийн өвчтэй, тусгай газар байх шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тавигдах шаардлага нь энэхүү стандартад хамаарахгүй.

5 Иргэний зориулалттай барилгад тавих үндсэн шаардлага

5.1 Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний үйл ажиллагааны (функцийн) үндсэн бүсчлэл

5.1.1 Хөдөлгөөнд оролцох үндсэн үйл ажиллагааны бүс болох хонгил, шатны хэсгийн талбай, гонх, хөлийн өрөөний (үүдний талбайн) өргөний хэмжээг тодорхойлохдоо тэргэнцэрийн эргэх тойргийн хэмжээг зайлшгүй харгалзах шаардлагатай. (А.хавсралт, А.1-р зураг, В.хавсралт, В.1-р зураг)

5.1.2 Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тоног төхөөрөмж, тавилгыг байршуулахдаа тэдний үйл хөдлөл хийхэд зориулсан (эргонометр) хэмжээ болон шаардлагуудыг зайлшгүй тооцох ёстой. Тэргэнцэртэй хүн нэг чиглэлд хөдөлгөөн хийх үеийн зорчих хэсгийн өргөн 1200мм, тэргэнцэртэй хоёр хүн зөрөх бол 1800 мм-ээс багагүй өргөнтэй байна. Тэргэнцэртэй ба ачаа тээш барьсан хүн болон тэргэнцэртэй хүүхэд нэг чиглэлийн хөдөлгөөнд орох бол зорчих замын өргөн 1500 мм байна. Зорчих замын нэвтрэх хэсгийн нарийсалтыг 850 мм хүртэл багасаж болно. (В1.хавсралт, В1.1-р зураг, С4.хавсралт, С4.1-р зураг)

5.1.3 Нэмэлт туслах хэрэглэл ашигладаг хүний үйл хөдлөлийн бүсчлэлийн талбайг тодорхойлохын тулд хүний ерөнхий хэмжээг харгалзана. Тухайн хүний “зогсох”, “суух” байрлалд эзлэх талбайн хэмжээг эрүүл хүний үндсэн хэмжээтэй харьцуулж ихэсгэн авч тооцно. Хөдөлгөөн хийхэд янз бүрийн туслах хэрэглэл (таяг, суга таяг, явахад туслах хэрэгсэл)-ийг ашигладаг хүний зорчих замын өргөний хэмжээ нь тулгуур хэрэгсэлийн төрлүүдээс хамааран 700 мм-ээс 950 мм-ийн хооронд хэлбэлзэнэ. (С.хавсралт, С.1, С.2, С4.2-р зураг)

5.1.4 Хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүн нь таяг болон хөтөч нохойны тусламжтай явах, хөдөлгөөнд орох тохиолдолд нохойтой хүн 800 мм х 1300 мм, таягтай хүн үндсэн хэмжээнээс хажуу тийшээ 200 мм, урд тал руу 800 мм-ээр ихэссэн хэмжээтэй бүсчлэл (орон зай)-ийг эзэлнэ. Хараагүй болон хараа муутай хүмүүс барилгын дотоод орон зайд ханын дагуу (А) явахдаа тавилга, тоног төхөөрөмж (Б), бариул, хашлага, хаалтаар баримжаалах (В) тул хараагүй согогтой хүмүүсийн ерөнхий хэмжээг хавсралтад заасны дагуу тооцно. (С. хавсралт, С1.1, С2.1-р зураг)

5.1.5 Хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүст зориулж барилга байгууламжийн дотоод орчинг бүрдүүлэхэд өндөр настай хүмүүсийн биеийн (антропометр) болон үйл хөдлөл хийхэд зориулсан (эргономик) хэмжээг заавал тооцно. (С3.хавсралт, С3.1-р зураг)

5.2 Барилга, өрөө тасалгааны орц болон хаалга

5.2.1 Иргэний зориулалттай (орон сууц, олон нийт) барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүний орох боломжийг хангасан налуу зам болон бусад тоног төхөөрөмжүүд (орох түвшин хүртэл хэрэглэх өргүүр)-ээр заавал тоногловсон байна. (D.хавсралт, D.1-р зураг)

5.2.2 Тухайн барилгын орцын шийдэл, орц хаалганы байрлал, орчны тодорхой байдлаас хамааруулж тэргэнцэртэй хүний эргэлтийн хөдөлгөөн хийхэд зориулсан хувилбарыг хавсралтад зааснаар сонгоно. Өгөгдсөн талбайн ерөнхий хэмжээ нь зөвхөн орцын хаалганы төрөл ба түүний онгойх чиглэлээс бус хаалга руу дөхөх үндсэн чиглэлээс хамаарч тодорхойлоно. (D1.хавсралт, D1.1-р зураг)

- 5.2.3** Барилгын орцын өмнөх талбай, налуу зам, шат нь өөрийн орны цаг уурын нөхцөлтэй уялдан хатуу гадаргуун хучилттай, халаах тоноглолтой, мөн (өргөх төхөөрөмжүүд зэрэг нь) хур тунадасаас хамгаалсан байна.
- 5.2.4** Хаалганы онгойх чиглэл ба байршлаас хамаарч гонхны (тамбур)-ын ерөнхий хэмжээ нь хавсралтад (D2.хавсралт, D2.1-р зураг) заасан хэмжээнээс багагүй байна.
- 5.2.5** Барилга, өрөө тасалгааны гол хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой 850 мм-ээс багагүй өргөнтэй, орон зай нь уужим цэлгэр байна. Хаалганд хэрэглэсэн нугас, эргэх хөдөлгөөний тоноглолуудыг хамааруулж үзэхгүй. Хаалгыг хаах онгойлгох байрлалд түүнийг тогтоох тусгай хэрэглэлүүдээр тоноглож болно. Хаалга нь автоматаар онгойж, дэлгэгддэг, эсвэл хавтастай байж болно. Автоматаар онгойдог шилэн хаалгыг төлөвлөхөд шалнаас 1500 мм-ийн өндөрт тод өнгөөр тэмдэглэгээ тавьсан байна. Барилгын орц, өрөө тасалгааны хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулж босгогүй байх ба хэрэв босготой бол өндөр нь 25 мм-ээс илүүгүй байна. (D3.хавсралт, D3.1-р зураг)
- 5.2.6** Орцын хаалганы хавтсанд доргилт, цохилтонд тэсвэртэй шилэн хавтасны доод ирмэг шалны түвшнээс 900 мм-ээс ихгүй өндөрт байхаар суулгаж өгнө. Хаалганы шилэн хавтасыг дундаа төмөр тортой(арматуртай), эсвэл хатуулаг шилээр хийнэ. Хаалганы хавтасны доод хэсэг нь цохилт доргилтоос хамгаалж 300 мм-ийн өндөртэй хамгаалах бүстэй байна. Хаалганы бариулын гадаргуу нь гар хүрэхэд эвтэй, гарын хуруу буюу шууны хөдөлгөөнөөр хөнгөхөн онгойдог, хаалгыг онгойлгож хаах үеийн дээд хүч нь 2.5 кг-аас ихгүй байна. (D4.хавсралт, D4.1-р зураг)
- 5.2.7** Хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хаалга нь ашиглах үеийн аюулгүй байдлыг хангасан, чиглэл (байрлал)-ийг хөнгөвчилсөн байдлаар тоноглогдсон байх ёстой. Хаалганы байрлал, өрөө тасалгааны зориулалт, хаалганы онгойх чиглэл, тэмдэглэгээний байрлал зэргийг мэдээлэх зохистой систем болох дуу авиа үүсгэгч, тод харагдахуйц бичиглэлээр тоноглоно. Шилэн хавтастай хаалгыг ашиглах үед ханан дээр шалны түвшнээс 1600мм-ийн өндөрт 150мм-ийн өргөнтэй сэрэмжлүүлэх өнгөт зурвасыг хэвтээ чиглэлд зурж тэмдэглэнэ. Орох, гарах хаалганы хавтсыг өөр өөр өнгүүдээр ялгаж өгнө. Орох хаалганы баруун гар талд 1000-1100мм-ийн өндөрт өрөөнүүдийн болон барилгын дугаарыг ялтсан дээр товойлгон дүрсэлж (кирилл тоогоор), бэхэлсэн байна. (D5.хавсралт, D5.1-р зураг)

5.3 Налуу зам (пандус)

- 5.3.1** Нэг налуу замын өргөлтийн өндөр 800 мм-ээс, налууугийн өнцөг 1:12-оос ихгүй, 200 мм-ийн өндөрт гарах бол 1:10-аас ихгүй, хөндлөнгийн налуу 1:50-аас хэтрэхгүй байх ёстой. Налуу замын болон талбайн гадна хүрээний далангийн өндөр 50мм-ээс багагүй байна. (D6.хавсралт, D6.1-р зураг)
- 5.3.2** Налуу замын эхлэл, төгсгөлд тэгш талбай байгуулах ба түүний урт нь налуу зам (пандус)-ын өргөнөөс багагүй буюу 1500мм-ээс багагүй байна. Налуу замын чиглэл өөрчлөгдөх тохиолдолд тэгш талбайн өргөн нь тэргэнцэр эргэх боломжтой байх ёстой. Налуу замын өргөн нь зорчих замын гарцын үндсэн хэмжээтэй уялдан зохицсон байна. (D6. Хавсралт, D6.1-р зураг)

5.3.3 Налуу замын хоёр хажуу талаар 900 мм-ээс багагүй өндөрт бариул бүхий хашлага хийнэ. Бариулыг хоёр эгнээгээр байрлуулж, тэдгээрийн өндөр нь 700 мм ба 900 мм байна. Сургуулийн өмнөх насныханд зориулж 500 м өндөрт бариул төлөвлөж болно. Хэвтээ талбай дээр бариул 300 мм үргэлжилж төгсөнө. Бариулын хөндлөн огтлолын оновчтой хэмжээ нь дугуй хэлбэртэй бол 30 мм-ээс 50 мм, тэгш өнцөгт хэлбэртэй бол хөндлөн огтлолын зузаан 40 мм, хана бариул хоёрын хоорондох зай 45 мм байна. Налуу замын бариулын хийц шатны бариулын хийцтэй адилхан байна. (D7.хавсралт, D7.1-р зураг)

5.4 Шат

5.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүн явах, зорчиход зориулсан шатны гишгүүр ба зам нь нийтдээ нүх сүвгүй битүү, гадаргуу нь жигд тэгш байх ёстой. Гишгүүрийн ирмэгийг дугуйлах ба радиус нь 50 мм-ээс багагүй байна. Шатны гишгүүрийн хананы эсрэг хажуугийн хаалтын өндөр 20 мм-ээс багагүй байх ёстой. Шатны гишгүүрийн өргөн гадна шатанд 400 мм-ээс багагүй, дотор шатанд 300 мм-ээс багагүй, гишгүүрийн өндөр гадна шатанд 120 мм-ээс ихгүй, дотор шатанд 150 мм-ээс ихгүй байна. (E.хавсралт, E.1-р зураг)

5.4.2 Шатны хоёр хажуу талыг бариулаар тоноглоно. Бариулыг гишгүүрийн гадаргуугаас 900 мм-ийн өндөрт, хүүхдэд зориулсан бариулыг 700 мм-ийн өндөрт байрлуулна. Бариулыг шатны талбай дээр 300 мм-ийн урттай үргэлжлүүлж дуусгана. (E.хавсралт, E.1-р зураг)

5.4.3 Хараагүй болон сул хараатай хүнд зориулж шатны гишгүүрийг дээрээс нь доош, бариулын хэсэг, шатны эхлэл, төгсгөлийн гишгүүрийн талбайн гадаргууг барзгар болгох буюу тод өнгөөр тэмдэглэнэ. Гишгүүрийг тод өнгөөр ялгаж будах буюу гишгүүрийн гадаргууг гэрэлтэй өнгөөр, ирмэгийг хар бараан өнгөөр ялгаж болно. Гишгүүрийг доороос гэрэлтүүлж болно. (E1.хавсралт, E1.1-р зураг)

5.4.4 Шатны гишгүүрийн тоо 3-аас багагүй байна. Шатны гишгүүрийн тоо хөгжлийн бэрхшээлтэй хүн явах, зорчих замын дагуу ижил байна. Шатны эргэлт бүрд шатны бариул дээр “Брайл”-ын тэмдэглэгээгээр, эсвэл кирилл тоог товойлгон давхрын тоо болон анхааруулах бичиглэл хийнэ. Шатны үргэлжилсэн гишгүүрийн доор 2100 мм-ээс багагүй өндөртэй бүсэд сэрэмжлүүлэх хашилт, хаалтыг байрлуулна. (E1.хавсралт, E1.1-р зураг)

5.5 Хонгил ба гарах зам (гарц)

5.5.1 Хонгилын ба гарц замын өргөн нь тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход хүрэлцээтэй хэмжээнд байх ёстой. Тэргэнцэртэй хоёр хүн зөрөх бол 1800 мм, нэг чиглэлийн хөдөлгөөнтэй бол 1200 мм-ийн өргөнтэй байна. (F.хавсралт, F.1-р зураг)

5.5.2 Орон сууцны барилга, нэг айлын сууцны хонгилын өргөн 0.9 м-ээс багагүй байна. Гарцын хамгийн бага өргөн нь хонгилын хөдөлгөөнийг хааж саад учруулахгүй байх ёстой. Хавсралтад заасны дагуу тэргэнцэр хонгилд 90°-аар хамгийн бага зайд эргэхэд зориулсан бүсийг (талбай) гаргах бөгөөд хонгилын төгсгөлд тэргэнцэр 180°-ийн эргэлт хийх бололцоог зайлшгүй хангах ёстой. (F.хавсралт, F.1-р зураг)

- 5.5.3** Хонгил, гарцын өргөнийг тогтооход чөлөөт бүсийн өргөний хэмжээгээр биш, гол нь хаалганы онгойх чиглэл, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлгөөнд зориулсан орон зайг зайлшгүй тооцсон хэмжээ байх ёстой. (F1.хавсралт, F1.1-р зураг)
- 5.5.4** Задгай талбай ба хонгилын хананд том хүн, янз бүрийн насны хүүхдэд зориулж 900 мм, 700 мм, 500 мм-ийн өндөрт үргэлжилсэн бариулыг тоноглох ёстой. Түүнээс гадна хараагүй хүн явах, зүг чигээ тогтооход зориулж тод өнгөөр будсан зурвас бүсийг тэмдэглэнэ. (F2.хавсралт, F2.1-р зураг)
- 5.5.5** Орцын өндөр нь (тоноглол хийцийн доод ирмэг хүртэл) 2100 мм-ээс багагүй байна. Хананд тавьсан элементүүдийн (харилцуур утасны бүхээг, мэдээллийн самбар г.м) өндөр 700 мм-ээс 2100 мм хүртэл, зузаан 100 мм-ээс ихгүй, тусгаар босоо тулгуурт байршуулсан бол 300 мм-ээс ихгүй өргөнтэй байна. (F2.хавсралт, F2.1-р зураг)
- 5.5.6** Хавтгай гадаргууд (хананд) байрлуулсан элементийн өнгийлт 100 мм-ээс ихгүй, түүний доорх орон зай, шалан дээрх (тавцан) хаалтын өндөр 100 мм-ээс багагүй өндөртэй байна. Хананд байрлуулсан элементийн доод ирмэг шалнаас 700 мм-т байна. Хананд тогтоосон (өлгөсөн) зүйлүүд, тоноглол элементүүд нь хонгилын өргөнийг хамгийн бага хэмжээнд хүргэх өнгийлттэй байхыг хориглоно. (F3.хавсралт, F3.1-р зураг)
- 5.6 Цахилгаан шат ба өргүүр**
- 5.6.1** Барилгын нэг давхрын өндрөөс багагүй ялгаатай түвшинд, налуу замыг төлөвлөх боломжгүй нөхцөлд тэргэнцэртэй хүн өөрөө ашиглах боломжтой тусгай өргөх төхөөрөмжүүдийг байрлуулна. (G.хавсралт, G.1-р зураг)
- 5.6.2** Барилгад нэвтэрч ороход янз бүрийн хийцийн өргүүрийг хэрэглэх бөгөөд 1800 мм хүртэлх түвшний ялгаатай тохиолдолд задгай тавцанг ашиглаж болно. Нэгээс дээш давхарт гарахын тулд задгай (нээлттэй) эсвэл хаалттай тасалгаа(кабин) бүхий төмөр утсан татуургатай өргүүрийг ашиглаж болно. (G3. хавсралт, G3.1-р зураг, G3.2-р зураг)
- 5.6.3** Өргүүр нь хөдөлгөөнт тавцан байх бөгөөд босоо чиглэлд, эсвэл шатны гишгүүрийн дагуу шилжилт хийх боломжтой хийгдэнэ. Өргүүрийн өргөн 900 мм-ээс, гүн нь 1200 мм-ээс багагүй байна. (G.хавсралт, G.1-р зураг)
- 5.6.4** Бүх төрлийн барилга дотор тэргэнцэртэй хүн ашиглахад зориулж цахилгаан шат төлөвлөнө. Цахилгаан шатны тасалгаа(кабин)-ны өргөн 1100 мм, гүн нь 1500 мм, хаалганы өргөн 850 мм-ээс багагүй байна. (G1.хавсралт, G1.1-р зураг)
- 5.6.5** Цахилгаан шат нь давхар бүрт, мөн тасалгаа(кабин)-ны дотор бие даасан удирдлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж том товчлуурыг товойлгон байршуулж, тоон цифрийг босоогоор тод томруун бичсэн байна. Цахилгаан шатны тасалгаа(кабин)-ны шал ба барилгын давхрын шалны түвшин хоорондын ялгаа 25 мм-ээс ихгүй байна. Давхруудын байрлал, өрөө тасалгааны дугаарыг зарлах зориулалтаар цахилгаан шатны тасалгаа(кабин)-г дуу үүсгэгчээр тоноглоно. (G1.хавсралт, G1.1-р зураг)

5.6.6Цахилгаан шатны хаалганы өмнө, тавцан дээр нэвтэрч орох орцын өмнө тэргэнцэртэй хүн эргэх хөдөлгөөн хийх хангалттай чөлөөт бүсийг (орон зай) зайлшгүй гаргана.

5.6.7Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж олон давхар орон сууцны барилгад хаалга нь 850 мм-ээс багагүй өргөнтэй цахилгаан шатыг тоноглож суулгана. Цахилгаан шатны өмнөх талбайн өргөнийг хаалганы талд 250 мм зай авч тогтооно. Өлгөмөл хаалгатай бол бариултай талд 700 мм, бүхэлдээ 2100мм-ээс багагүй өргөнтэй байна. (G2.хавсралт, G2.1-р зураг)

5.7 Ариун цэвэр-эрүүл ахуйн зориулалттай өрөө

5.7.1Ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд зориулсан нэгээс доошгүй тасалгааг төлөвлөх ба түүний хамгийн бага урт, өргөний хэмжээ 1650 мм х 1800 мм байна. (H.хавсралт, H.1-р зураг)

5.7.2Нийтийн бие засах хэсгийн нэг өрөө(кабин)-г тулууур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж хажуугийн хана дагуулсан бариул, хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулж төхөөрөмжлөнө. (H1.хавсралт, H1.1-р зураг)

5.7.3Бие засах өрөөний орцын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй харах боломжтойгоор таних тэмдэгүүдийг өнгөөр болон товойлгон бичиж байрлуулах ёстой. Таних тэмдэгүүд нь бүх барилгад адил байна. Эрэгтэй, эмэгтэй хүн бие засах өрөөг цуг(нэг дор) байршуулахыг хориглоно.

5.7.4Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцэрээс суултуур дээр шилжиж суух боломжийг хангахын тулд ариун цэврийн өрөө(кабин)-нд байгаа суултуурын хажуу хэсэгт тэргэнцэр байршуулах чөлөөт орон зай (талбай) гаргана. (H. хавсралт, H.1-р зураг)

5.7.5Эрэгтэй хүний нийтийн бие засах өрөөнд шалнаас 400мм өндөрт нэгээс доошгүй тооны хөтөвч (писсуар)-ийг байршуулах ба түүний хоёр хажуу талд тулж барих бариулыг босоо чиглэлд тоноглоно. (H2.хавсралт, H2.1-р зураг)

5.7.6Нийтийн зориулалттай бие засах өрөөний гар угаах хэсэгт нэгээс цөөнгүй тосгуурыг шалнаас 800 мм-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 200 мм-ээс багагүй зайд, толь, гар хатаах төхөөрөмж болон гар нүүрийн алчуур хатаах өлгүүрийг (доод ирмэг хүртэлх зай) шалнаас 900 мм-ээс ихгүй өндөрт байршуулна. (H3.хавсралт, H3.1-р зураг)

5.7.7Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан шүршүүрийн өрөө нь 800 мм х 900 мм-ээс багагүй хэмжээтэй, тулах гар бариул, хөдөлгөөнгүй бэхэлсэн түшлэгтэй сандал зэргээр тоноглогдсон байна. Шүршүүрийн өрөөний өмнө хэсэгт тэргэнцэртэй хүн саадгүй орж ирэх хангалттай орон зайг бүрдүүлнэ. (H4. хавсралт, H4.1-р зураг)

5.7.8Усанд орох өрөөнд тэргэнцэртэй хүний хөдөлгөөнд зориулсан хангалттай чөлөөт орон зайг бүрдүүлэх ёстой. Усанд орох онгоцыг хананд бэхэлсэн гар бариул, онгоцны ирмэг дээр суух суудлаар тоноглоно. (H5.хавсралт, H5.1-р зураг)

5.8 Зориулалтын бүсчлэл

- 5.8.1** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтээр ашиглахад зориулсан нэгээс цөөнгүй харилцуур (таксофон)-ыг шалны гадаргуугаас 850 мм-ээс 1100 мм-ийн өндөр байршуулна. Тэргэнцэртэй хүн хүрч очиход зориулсан орон зай бүхий харилцуур утасны бүхээг (кабин)-ны хэмжээ 1400 мм х 1200 мм байх ёстой. (I. хавсралт, I.1-р зураг)
- 5.8.2** Тэргэнцэртэй болон хөдөлгөөн хязгаарлагдмал хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бүсэд 2÷3 амрах байрыг тэргэнцрээр эргэх хөдөлгөөн хийж зорчих зориулалттай тусгай талбай бүхий “карман” өрөөний төрлөөр амрах бүсчлэлтэй нэгтгэн төлөвлөж болно. (J. хавсралт, J.1-р зураг)
- 5.8.3** Хооллох болон зуушны газрын түгээх хэсэг ба зорчих хэсгийн өргөн 1200 мм-ээс багагүй, буфет (зуушны хэсэг) болон түгээх хэсэг рүү хөгжлийн бэрхшээлтэй хүн дөхөж очих нөхцөл сайн байх ёстой. Хоёр ширээний хоорондох зай 900 мм-ээс багагүй, зорчих хэсгийн өргөн 1800 мм, хана болон ширээний хоорондох зай 1200 мм-ээс багагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан байрыг ханын дэргэд гаргасан бол тулгуур гар бариул, таягны өлгүүр зэргийг 900 мм-ийн өндөрт байршуулах хэрэгтэй. (K. хавсралт, K.1-р зураг)
- 5.8.4** Буфет(зууш), “Бар”-ны хэсэг дэх лангууг хөгжлийн бэрхшээлтэй хүний өндөрт зохицуулж хангалттай хэмжээнд байрлуулна. Тэргэнцэртэй хүнд зориулж лангууны дэргэд тусгай талбай гарган шалны түвшинг хангалттай өндөрсгөсөн байна. (K. хавсралт, K.2-р зураг)
- 5.8.5** Тэргэнцэртэй хүнд зориулсан харж ойлгох мэдээлэлийг зорчих замын гадаргуугаас 1700 мм-ээс ихгүй, 900 мм-ээс багагүй өндөрт тод өнгийн дэвсгэр дээр байрлуулсан байна. Хамгийн тод томруун тодорхой харагдах бүсийн байрлал нь цонхны суулгац зориулалтаас хамаарна. (L. хавсралт, L.1-р зураг)

5.9 Хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцох

- 5.9.1** Хараа муутай хүмүүст зориулж шулуун замаар зорчих хөдөлгөөнийг тасралтгүй хангах, гэрэлтүүлэг сайн байх нөхцлийг барилгын эзлэхүүнт төлөвлөлтөд хангасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих замын дагуу багана, тулгуур хийц болон саад болох зүйлүүдээс зайлж гарах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг урьдаас төлөвлөж тавьсан, аюултай хэсгүүдэд хаалт хашилт хийсэн байна.
- Бүх давхруудын шат, цахилгаан шатны өмнө хэсэгт 900 мм-ийн өргөнтэй тактильный (резинэн товгор гадаргуу) гүдгэр гадаргууг төлөвлөнө. Цахилгаан шатны тасалгаанд(кабин) давхруудын тоог мэдээлэх зориулалттай дуу хүлээн авагчаар тоноглож, тэргэнцэртэй хүн эргэх хөдөлгөөн хийх, зорчих хэсэгт саад болохооргүй орон зайг бүрдүүлнэ. 1-р давхрын товчлуурыг бусад товчлууруудаас хэмжээ болон өнгөөр ялгаж хийнэ.
- 5.9.2** Хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж барилгын өрөө тасалгааны гэрэлтүүлэг хамтатгасан байж болно (байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг). И Ойлтын коэффициентоос хамаарч өрөө тасалгааны болон тоног төхөөрөмжийн гадаргуу дээрх сул (бүдэг) өнгийн ойлтын эзлэх хувь дараах байдалтай байна.

Үүнд: тааз 70 %, хана 60 %, дээд доод бүс 50 %, тоног төхөөрөмж 35 %, шал 25%-иас 30% байна.

5.9.3 Өрөө тасалгаанд явагдах үйл ажиллагааны шинж чанараас хамаарч 500 лк— ээс 1500 лк хүртэл гэрэлтүүлэг хангахаар тухайн хэсэгт болон ерөнхийд нь гэрэлтүүлгийн хосолмол систем, зохиомол гэрэлтүүлгийн төхөөрөмжөөр тоногдсон байна. Энэ түвшинд ерөнхий гэрэлтүүлгийн системээс гэрэлтүүлэг 500 лк хүртэл байх ёстой.

5.9.4 Тухайн байран дээр гэрэлтүүлгийн гийгүүлэлт их хэмжээнд биш, гэрлийн урсгалын чиглэл ба өндрийн өөрчлөлт боломжтой, сууринд сайн бэхэлсэн байна.

5.9.5 Хараагүй бэрхшээлтэй хүн ашиглах зориулалтаар өрөө тасалгаа ба хонгилд аюул аваараас хамгаалсан дохионы гэрлийг байрлуулна. Шалан дээрх гэрэлтүүлгийн түвшин 0.5 лк-ээс багагүй байна. Өөртөө үйлчлэх хувцасны өлгүүрийн өрөө, шүүгээтэй хэсэгт хаалга онгойлгоход автоматаар асдаг гэрэлтүүлэх төхөөрөмжийг суурилуулсан байна.

5.9.6 Булангийн хана, захын шүүгээ бүрийн дээр шалнаас 1550 мм-ээс 1600 мм-ийн өндөрт шүүгээний болон эгнээний дугаарыг товойлгон бичиж тогтоосон байна.

5.9.7 Барилгын өрөө тасалгаан дахь боломжтой дуу авианы горим (40Дб-ээс ихгүй), чимээ шуугианаас хамгаалах арга хэмжээ нь хана таазны өнгөлгөөнд дуу чимээ шингээгч хийц бүтээцийг дуу тусгаарлагч болгож ашигласан байна. Өнгөлгөөний хавтанцрын гадаргуугийн 20 %-аас багагүй талбайд 3-аас 5 минутийн диаметр(голч)-тэй шивүүр нүх гаргаж өгнө. Ийм гадаргуу байхгүй тохиодолд дуу шингээгч ширхэгэн хавтанцруудыг дуу шингээх дэлгэц (экран), дүүжин элементүүд болгон ашиглаж болно. Ширхэгэн дуу авиа шингээгчийг шивүүр нүхтэй хуудсан бүрхүүл бүхий хавтанцрын дотор талыг дуу шингээгч материалаар дүүргэж хийх ба уг хавтанцраа чимээ шуугиан үүсгэгчийн ойролцоо байрлуулж тавина.

5.9.8 Хараагүй бэрхшээлтэй хүнд зориулж саад тотгор ойртож буйг урьдчилан мэдээлэх зорилгоор шалны гадаргууг өвөрмөц байдалд засах ба өнгөний өөрчлөлт оруулан өөрчилж өгнө. (М.хавсралт, М.1-р зураг)

5.10 Сонсголгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцох

5.10.1 Дүлий болон сул сонсголтой хүмүүст зориулж барилгын доторх орон зай, бүсчлэлийн үндсэн хэмжээг өөрчлөхөд бус эхний шатанд мэдээллийг зайлшгүй хүлээн авах шаардлагаар өрөө тасалгааны дуу авиа сонсогдох байдлын (харилцааны) төлөвлөлтийг боловсруулах ёстой.


5.10.2 Дуу үүсгэгчээс гарах дуу авиа зогссоны дараа үргэлжлэх (ревербераци) хугацаа болон үг ярианы реверберацийн үргэлжлэх хугацаа нь сул сонсголтой хүнд богино хугацаанд ялгамжгүй хүрч байна.

5.10.3 Сонсгол муутай хүмүүст сайн сонсох хандлагыг хөнгөрүүлэхэд зориулж дуу чимээ шингээгч гадаргууг бэлтгэх ба энэ нь хивсэн зөөлөвтэй гадаргуу, дүүжин тааз (үет хавтанцар) эсвэл шивүүр нүхтэй хавтанцар гадаргуу байна.

- 5.10.4** Сонсгол муутай хүмүүст зориулж нийтийн зориулалттай харилцуур утасны дунд тодоор тэмдэглэсэн индуктив (нөлөөлөл сайтай, нэгтгэн дүгнэх) харилцуур утсыг (аппарат) байршуулж тавина.
- 5.10.5** Мэдээллийн үйлчилгээний бүсэд худалдааны цэг, цайны газрын лангууны хэсэгт уншиц сайтай гэрэлтүүлгэн самбарыг байршуулна. Энэ бүсэд хараад шууд ойлгож мэдрэхэд дөхөмтэй туяа, гэрлийн ойлт тусгал сайтай шилэн самбарыг байршуулна.
- 5.10.6** Барилгын дүлий болон сул сонсголтой хүмүүсийн байнга оршин суудаг хэсэгт дуу өсгөгч нэмэлт системийг байршуулна.
- 5.10.7** Сонсголгүй хүмүүст үг яриа, харилцааг бэрхшээл багатай хүргэхийн тулд барилга байгууламжийн орцны хэсгээс өрөө, тасалгаа хүртэл мэдээллийн зохистой системээр тоноглож хангасан байна.
- 5.10.8** Өрөө тасалгаа бүр маш нарийн тэмдэглэгдсэн, том хэмжээтэй сайн гэрэлтүүлэг бүхий тэмдэгтэй байна.
- 5.10.9** Барилга байгууламжид дэлгэц ба хүснэгт нь мэдээлэлтэй хамтатган дуу авиан мэдээллийг зайлшгүй байршуулна. Галын аюулын дохиоллын систем нь гэрлэн ба дуун авианы хосолмол байна. (M1.хавсралт, M1.1-р зураг)

ТӨГСӨВ.

**А.хавсралт
(норматив)**




А.1-р зураг - гэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүн зориулсан үйл ажиллагаа, орон зайн бүсчлэлийн гол хэмжээ

- А - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг байршуулах бүсчлэл
- Б - Тэргэнцрийн хэмжээ
- В - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний үйл хөдлөл хийх боломжтой хэмжээ

Моделийн бага тоон утга нь барилгын доторх өрөө тасалгаанд зориулагдсан хэмжээ, том тоон утга нь барилгын гадна гудамж, зам талбай, өрөө тасалгааны дотоод орон зайд хэрэглэгдэх хэмжээ болно.

В.хавсралт (норматив)




В.1-р зураг - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний үйл ажиллагааны (функциональ) үндсэн бүсчлэл

А. Тэргэнцэрийн анхны байрлал, эргэлтийн чиглэл (90°-д эргэх тэргэнцэрийн бүсчлэл)

Б. Тэргэнцэрийн эргэх үеийн байдал (180°-д эргэх тэргэнцэрийн бүсчлэл)

В. Эргэлт хийх бүсчлэлийн хязгаар (360°-д эргэх тэргэнцэрийн бүсчлэл)


**В1.хавсралт
(норматив)**



В1.1-р зураг - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан үндсэн бүсчлэл

- А. Дээрээс харсан байдал
- Б. Хажуу талаас харсан байдал
- В. Эгц урдаас харсан байдал
- 1- хөдөлгөөнгүй байдал дахь хязгаар
- 2- хэлтийх хөдөлгөөний үеийн төлөв хязгаар
- эмэгтэй хүнд зориулсан хязгаар
- эрэгтэй хүнд зориулсан хязгаар


**С.хавсралт
(норматив)**




С.1-р зураг - Нэмэлт тоноглол (таяг, тулах хэрэгсэл) хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан, ерөнхий ба гол хэмжээ

А. Хажуугаас харсан байдал Б. Дээрээс харсан байдал

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн үзэгчдийн эгнээнд суусан байдал
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ширээний хажуугаар орж ирж байгаа болон ширээний дэргэд сууж буй байрлал
3. Сууж буй хүний хажуугаар явж буй байрлал



С.2-р зураг - А. Хажуугаас харсан байдал Б. Дээрээс харсан байдал
 1. Усанд орох онгоц (ванны)-ны дэргэдэх байрлал
 2. Унтаж хэвтэх орны дэргэдэх байрлал
 3. Гар нүүр угаагуурын дэргэдэх байрлал
 4. Хувцасны шүүгээний дэргэдэх байрлал


**С1. Хавсралт
(норматив)**

**С1.1-р зураг – Хараагүй хүний ерөнхий овор хэмжээ
(габарит)**


С2.хавсралт
(норматив)

A.

Б.




B.



С2.1 зураг – Хараагүй хүний үйл хөдлөл хийх (эргонометр) ерөнхий хэмжээ

СЗ.хавсралт (норматив)




СЗ.1-р зураг - Өндөр настай хүний үйл хөдлөл хийхэд зориулсан (эргонометр) хэмжээ

А. Урдаас харсан байдал Б. Хажуу талаас харсан байдал
В. Дээрээс харсан байдал


- 1.Зогсож буй хүний ерөнхий овор хэмжээ 2.Хүрэх бүсчлэл
3.Харах ашигтай талбай (бүс) 4.Суугаа байдал дахь ерөнхий хэмжээ ба төхөөрөмж байршуулах, ажиллахад ашигтай, ая тухтай орон зай (Хаалтанд оруулсан хэмжээ нь эрэгтэй хүнд зориулсан болно.)

С4.хавсралт
(норматив)


С. А.



Б.




В.



С4.1-р зураг - Тулгуур эрхтэний гэмтэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлгөөн хийх үеийн (эргономик) хэмжээ

- А-1 талын хөдөлгөөний үед
- Б-2 талын хөдөлгөөний үед
- В-Тэргэнцэртэй 2 хүн зөрөх хөдөлгөөн
- Г-зорчих хэсгийн тухайн хэсэг дэх нарийсалт




С4.2-р зураг -


- А. Таяггүй хүн
 Б. Нэг таягтай хүн
 В. Хоёр таягтай хүн
 Г. Тохойгоор тулах 2 таягтай хүн
 Д. Хоёр суга таягтай хүн
 Е. Тухайн хүнд тохируулсан тулгуур таягтай хүн

D.хавсралт
(норматив)

A.




Б.



D.1-р зураг - Орцын шат, налуу зам, тоног төхөөрөмж

- A. Дээрээс харсан байдал
 - 1. Урьдчилж сэрэмжлүүлсэн зурвас бүс
- Б. Хажуугаас харсан байдал


D1.хавсралт (норматив)



D1.1-р зураг - Барилгад болон өрөө тасалгаанд тэргэнцэртэй хүн ороход зориулсан орцын бүсчлэлийн ерөнхий хэмжээ

- А. Хаалга дотогшоо онгойх байдал
- Б. Хаалга гадагшаа өөр рүү онгойх байдал
- В. Хаалга өөрөөс гадагш онгойх байдал

D2.хавсралт
(норматив)




D2.1-р зураг - Гонхны (тамбур) төхөөрөмж, орцын өмнөх талбай, тоноглол


- А. Гонхны дотор чиглэлд хаалга онгойх үеийн хэмжээ
- Б. Гонхны 1 хаалга гадагшаа онгойх үеийн хэмжээ
- В. Тэргэнцэртэй хүн 90° -ийн эргэлт хийх үед хаалга гадагшаа онгойх үеийн хэмжээ
- Г. Хоёр хавтастай хаалга гадагшаа онгойх хэмжээ

D3.хавсралт (норматив)

A.




Б.



D3.1-р зураг - Орох хаалганы төрөл

- A. Янз бүрийн төрлийн хаалганы өргөн, орчны орон зайн хэмжээ
1. Нэг хавтастай (далавчтай) хаалга
 2. Нэг талын хавтас нь хаалганы өргөний хагас хэмжээтэй хаалга
 3. 2 хавтастай хаалга
 4. Гулсаж хөдөлдөг хаалга
 5. Эвхэгддэг хаалга
- Б. Босгогүй хаалганы шийдэл


D4.хавсралт
(норматив)



D4.1-р зураг - Тулгуур эрхтэний тоноглолтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж орц, хаалгыг тоноглож, төхөөрөмжлөх байдал

- А. Нэг хавтастай хаалга
- Б. Хоёр хавтастай (далавчтай), анхааруулах зурвас тэмдэглэгдсэн шилэн хаалга
- В. Хаалганы бариулын байрлалын хэмжээ
- Г. Хаалганы код байрлуулах бүс(1),
тоон тэмдэг бүхий давхрын дугаар(2), дуудах хонх(3)


D5.хавсралт (норматив)




D5.1-р зураг - Харааны согогтой хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орц, хаалганы тоноглолууд

- А. Хаалганы 2 талд зүг чиглэлийг заасан өнгөт зурвасаар гадаргууг өөрчилсөн тэмдэглэгээ
- Б. Хаалганы өмнө хэсэгт гадаргууг өөрчилсөн өнгөт тэмдэглэгээ
- В. Гэрлэн дохиололтой дуудах төхөөрөмж
- Г. Хаалганы онгойх чиглэлийг заасан тэмдэглэгээ
- Д. Хаалганы үүрийг хүрээлүүлж өнгөөр болон гадаргууг өөрчилж ялгасан байдал
- Е. Уян хатан материалаар завсар, зайг бөглөсөн байдал


D6.хавсралт
(норматив)



Г.




Д.



Д6.1-р зураг - Налуу зам (пандус)-ын ерөнхий гол хэмжээ (параметр)

- А. 0,2 м-ийн өндөрт гарах налуу зам
 - Б. 0,8 м-ийн өндөрт гарах налуу зам
 - В. Налуу замын хөндлөн огтлол
 - Г. 0,8м-ээс дээш өндөрт гарах налуу зам
 - Д. 1,5м-ийн өндөрт гарах налуу замын байгуулалт
1. Байгуулалт 2. Зүсэлт


D7.хавсралт
(норматив)



D7.1-р зураг - Хашлага ба бариулын хэлбэр, хэмжээ

- A. Бариулын хөндлөн огтлолын хэлбэр, хэмжээ
- Б. Бариулын төгсгөл хэсэг
- В. Налуу замын захын хашлага байршуулсан байдал


Е.хавсралт
(норматив)



Е.1-р зураг - Шат

А. Шатны гишгүүрийн шийдэл Б. Шатны бариулын шийдэл
В. Шатны хажуу захын хашлага, хаалтыг төлөвлөсөн жишээ

Е1.хавсралт
(норматив)




Е1.1-р зураг - Харааны соготой хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцон шатыг тоноглож төлөвлөх онцлог


- А. Зүг чигийн бүс байгуулах байдал
 - 1. Гишгүүрийн ирмэгийг өнгөөр ялгана.
 - 2. Резинэн товгор гадаргуу
- Б. Шатны доорх зайг хамгаалах байдал
 - 1. Урьдчилан сэргийлж хамгаалсан бүсчлэл

Ү.хавсралт
(норматив)


А.




Б.



В.



Г.




Ү.1-р зураг - Хонгил ба гарах зам (гарц)-ын гол хэмжээ (параметр)

- А. Нэг айлын сууцны доторх хонгилын өргөн
- Б. Тэргэнцэртэй хүн 1 чиглэлийн хөдөлгөөн хийх хонгилын өргөн
- В. Тэргэнцэртэй хүн 2 талын хөдөлгөөн хийх хонгилын өргөн
- Г. Хонгилын төгсгөл дэх эргэлт


F1.хавсралт
(норматив)

А.




A \square $a+b \geq 2300$
A' \curvearrowright $a'+b \geq 2000$


Б.



В.




Г.



F1.1-р зураг - Хонгилын гол хэмжээ (параметр)

- А. Явах замын дагуух хаалганы байршил ба 90° эргэлттэй хонгил (коридор)-ын байдал
- Б. 2 чиглэлд хөдөлгөөнтэй, хаалгагүй зорчих зам (гарц, гарах зам)
- В. 2 талын өрөөнөөс хаалга онгойх хонгил (коридор)
- Г. 1 талын өрөөний хаалга онгойх хонгил (коридор)


F2.хавсралт (норматив)



F2.1-р зураг - Нэмэлт тоноглолуудыг байрлуулах

- А. Ханын дагуу байршуулсан бариул, мэдээллийн өнгөт зурвас
 1. Чиглүүлэх бариул 2. Өнгөөр тэмдэглэсэн зурвас
 Б. Хана, таазанд угсарсан элементүүдийн байрлал
 В. Тулгуур хийцэд угсарсан элементүүдийн байрлал

Ү3.хавсралт
(норматив)



Ү3.1-р зураг - Нэмэлт тоноглолуудыг тогтоох


А. 0,7 м-ийн өндөрт угсарсан элементүүдийн байрлал

1. Өнгийлтийн хэмжээ хязгаарлагдахгүй
2. Хүний чөлөөтэй нэвтрэх (зорчих) хэсгийн өргөний хэмжээ
3. Сануулж, сэрэмжлүүлэх зориулалттай шалан дээрх тавцан (хаалт, хашилт)

Б. 0,7 м-т угсарч тогтоосон элементийн байршил

1. Өнгийлтийн хэмжээ хязгаарлагдахгүй
2. Таягийн хөдөлгөөний бүс


Г.хавсралт
(норматив)



G.1-р зураг - Барилга байгууламжид цахилгаан шат ба өргүүрийг байршуулах

- А. Босоо чиглэлд шилжилт хөдөлгөөн хийх өргүүр
 Б. Шатны гишгүүрийн чиглэлд шилжих өргүүр
1. Өргүүрийн тавцан
 2. Чөлөөт талбай (орон зай)
 3. Байнга ашиглагдахгүй шатны өргөн
 4. Байнгын ашиглагдах шатны өргөн


G1.хавсралт
(норматив)



G1.1-р зураг - Олон нийтийн зориулалттай барилга байгууламжуудыг тоноглох цахилгаан шат ба өргүүр

1. Эмнэлгийн зориулалттай цахилгаан шат
2. Хүн тээврийн цахилгаан шат
3. Чөлөөт бүс
4. Хүрэх боломжгүй бүс
5. Бариул
6. Налж суух сандал
7. Толь
8. Удирдах самбар


G2.хавсралт (норматив)



**G2.1-р зураг - Орон сууцны барилгад тоноглох
цахилгаан шат ба өргүүр**

- А. Тэргэнцэрт зориулсан кабинтай цахилгаан шат
- Б. Эмнэлгийн дамнуургаар зөөвөрлөх боломжийг тооцсон 2 хаалгатай цахилгаан шат
- В. 630 кг ачааны даацтай, 1100 мм х 2100 мм-ийн овор хэмжээтэй цахилгаан шат

G3.хавсралт
(норматив)



G3.1-р зураг - Олон нийтийн барилгад хөгжлийн бэрхиээлтэй хүний ашиглахад зориулсан өргүүрийн хувилбар


А. Налуу тавцан:

1. Хажуугийн хашлага (хөдөлгөх механизмтай тал)
2. Удирдах самбар
3. Түшлэгтэй сандал
4. Тавцан
5. Налуу тавцанг эвхсэн байдал

Б. Байран тавцан:

1. Налуу хашлага
2. Удирдлагын самбар
3. Түшлэгтэй сандал
4. Урьдчилж сэрэмжлүүлэх бүс


G3.хавсралтын үргэлжлэл



G3.2-р зураг - А. Шатны хажуу талаар шилжилт хийх өргүүр
 Б. Шатны бариулыг дагаж шилжилт хийх өргүүр
 В. Өргүүрийн эргэлт хийх шилжилт

1. Удирдах самбар 2. Түшлэгтэй сандал 3. Урьдчилж сануулах зурвас

Н.хавсралт (норматив)



Н.1-р зураг - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөөг төлөвлөх онцлог

А. Ариун цэврийн өрөө: (хамгийн бага хэмжээтэй)



1. Урд талаас харсан байдал
2. Хажуу талаас харсан байдал
3. Байгуулалт дээрх байдал

Б. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бие засах өрөөг нийтийн ариун цэврийн өрөөнүүдийн буланд байршуулсан байдал


1. Байгуулалтын схем
2. Ерөнхий эгнээнд байршуулсан байдал

Н1.хавсралт (норматив)

А.



Б.




Н1.1-р зураг - Тулах хэрэгсэл хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөө төлөвлөх онцлог

А. Дээрээс болон хажуу талаас харсан ариун цэврийн өрөөний байдал

Б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөний байршил (усны татуургыг хананд болон шаланд суурилуулна)

Н2.хавсралт (норматив)





Н2.1-р зураг – Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүнд зориулан нийтийн бие засах өрөөг төлөвлөх онцлог

А. Хажуу талаас харсан байдал

Б. Нүүр тал болон байгуулалт дээрх байдал


Н3.хавсралт
(норматив)



Н.3-р зураг - Бие засах өрөөний хэсэгт гар нүүр угаагуурыг төлөвлөх онцлог

1. Тэргэнцрийн байрлах талбай
2. Угаагуурыг тогтоох стандарт өндөр
3. Тэргэнцэртэй ХБИргэн ба хүүхдэд зориулсан тосгуур
4. Ус гоожуулах цоргоны зөвшөөрөгдсөн хийц


Н4.хавсралт (норматив)



Н4.1-р зураг - Усанд орох шүршүүрийн өрөөг төлөвлөх онцлог

1. Тэргэнцэртэй хүн хүрч очих бүс
2. Хөдөлгөөнгүй бэхлэгдсэн түшлэгтэй сандал
3. Бэхэлгээ төмрийн дагуу шилжилт хийх боломжтой уян хатан шүршүүр
4. Хэвтээ чиглэлийн гар бариул
5. Босоо чиглэлийн гар бариул
6. Хөшигөн ба эвхэгддэг хаалга
7. Цорго, хаалтуудыг (крант) байршуулах боломжит бүс


Н5.хавсралт (норматив)



Н5.1-р зураг - Усанд орох өрөөг төлөвлөх онцлог

1. Тэргэнцрийн хөдөлгөөн хийх бүс
2. Ирмэг дээрх суудал
3. Бэхэлгээний чиглэлд хөдлөх уян хатан шүршүүр
4. Хэвтээ чиглэлийн гар бариул
5. Босоо чиглэлийн гар бариул

I.хавсралт
(норматив)



I.1-р зураг - Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэх харилцуур утасны байршил

А. Харилцуур утасны кабин руу (шовгор) орох бүсчлэлийн хэмжээ

Б. Урд талаас харсан байдал

В. Ил байдлаар төлөвлөсөн автомат-харилцуур утасны байгуулалт дээрх байдал

1. Ил байршуулсан автомат – харилцуур утас

2. Харилцуур утасны шовгор (байр, өрөө)

3. Тэргэнцэртэй хүн хүрч очих бүс


4. Яаралтай дуудлага ба бусад мэдээллийн утасны жагсаалт

5. Харилцуур утасны лавлах байршуулах зориулалттай тавцан (байр)


6. Түшлэгтэй сандал

Ж.хавсралт (норматив)

А.



Б.




Ж.1-р зураг - Олон нийтийн барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүний амрах зориулалттай бүсчлэл

А. Ширээ тавьсан тусгаар бүс


Б. Буйдан дээр амрахад зориулсан болон эгнүүлж байрлуулсан талбай бүхий бүсчлэл

К.хавсралт (норматив)




К.1-р зураг - Хооллох болон зуушны газарт тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг байрлуулах зориулалтын талбайн (бүсийн) гол хэмжээ

- А. Цай түгээх төхөөрөмж, лангууны байдлыг зүсэлт зургаар үзүүлсэн байдал
- Б. Ширээний дэргэд ХБИргэнд зориулж гаргасан бүс
- В. Ширээг байршуулсан хувилбар



К.2-р зураг - А. “Баар”-ны лангууны зүсэлт
 Б. “Баар”-ны лангууны дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд гаргасан тусгай байр
 В. Хананы дэргэдэх ширээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж гаргасан байр


L.хавсралт
(норматив)



L.1-р зураг -Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон төлөвлөлтийн онцлог

- A. Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан мэдээллийн самбарын байрлал
- Б. Тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагад нийцүүлсэн цонхны байрлал
- В. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан товчлуур залгуурын байрлал

М.хавсралт
(норматив)




М.1-р зураг - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан анхааруулах товруутай резинэн гадаргуу бүхий хөтөч хавтан (барилгын дотор талд тавих)


- А. Шулуун хөдөлгөөнийг заах
- Б. “Анхаар эргэлт” хөдөлгөөнийг заах
- В. “Анхаар урсгал хөдөлгөөний огтлолцол”-ыг заах
- Г. “Анхаар зогс, шат” гэж заах

М1.хавсралт
(норматив)


A.



B.



Б.



**М1.1-р зураг - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан
анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ**

- A. Тэмдэг, тэмдэглэгээ бүхий мэдээллийн жишээ
- Б. Мэдээллийг хүлээн авах байдал, байршуулах зайнаас хамааруулж тэмдэглэгээний өндрийг сонгох байдал (үсэг, тоо, дүрс)
- В. Тэмдэглэгээ бүхий бүс